

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОУХНЦ	Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН  
НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ОДОНЧИМЭГ  
ТАНАА

2020.08.20 № 06/543  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон бусад стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Одончимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, анхан шатын баримтын бүрдлийг хангаж ажиллах, үндсэн хөрөнгийн болон бараа материалын дэлгэрэнгүй тайлан хөтлөлтийг хянаж баталгаажуулж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 8-наас 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Пийк ОМ Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 2/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Улс үндэстний хүүхэд, өсвөр залуу үеийг нийгмийн харилцааны үнэт баялаг, үндэсний ёс заншлаас суралцуулах, хүүхдийн эрхэд суурилсан хөгжлийг дэмжих, тэдний амарч, хөгжих эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, чанартай хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, хөгжлийн хөтөлбөрийн арга зүйг дэлгэрүүлэхэд оршино.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын үйл ажиллагааны чиглэлийг “Хүүхэд залуучуудын амралт, аялал жуулчлал” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, илүү цагийн нэмэгдэл хөлс олгох, ур чадварын нэмэгдэл олгох;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох;

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous 3.0 программ хангамж ашигладаг байна.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг нийт орлогын 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,788,729 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 47,887.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 49,852.9 мянган төгрөгөөр тооцсон нь Олон улсын найрамдал цогцолборын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,985,287.7 мянган төгрөгөөс тухайн байгууллагын эрсдлийг “дунд” гэж үнэлэн 1 хувийг сонгож тодорхойлсонтой холбоотой болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 534,869.5 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын хувь оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	351.9	13,449.8	13,097.9
Авлага	88,783.9	162,736.6	73,952.7
Урьдчилгаа	39,250.0	27,700.0	(11,550.0)
Бараа материал	674,128.5	725,750.8	51,622.3
Үндсэн хөрөнгө	15,158,334.8	14,496,342.3	(661,992.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>15,960,849.1</b>	<b>15,425,979.6</b>	<b>(534,869.5)</b>
Өр төлбөр	647,489.6	562,105.4	(85,384.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,313,359.5	1,483,874.2	(449,485.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>15,960,849.1</b>	<b>15,425,979.6</b>	<b>(534,869.5)</b>

Авлага дансны үлдэгдэл өссөн нь Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын ТГ/548 дугаар бичгийн дагуу үерийн гамшигт нэрвэгдсэн Оросын холбооны улсын Эрхүү мужийн хүүхдүүдийг амраасны төлбөрийг эрх бүхий байгууллага шийдээгүйгээс үүссэн болон байрны түрээсийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2018 онуудад үүссэн, он удаан жил болсон 46,163.1 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, 10,874.6 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. Уг авлагаас хариуцагчийн хаяг тодорхойгүй, барагдах боломжгүй эрсдэлтэй, 1,455.0 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь аж ахуйн бараа материал болон бусад хангамжийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалан өсчээ. Бараа материалын дансны үлдэгдэлд байгаа 725,750.8 мянган төгрөгийн бараа материал нь дулаан үйлдвэрлэлийг тасралтгүй явуулахад шаардлагатай засварын материал болон 20 хоногийн нүүрсний нөөц,

хүнсний материал, норм зөөлөн эдлэл, хүүхдийн тоглолтын хувцас, бага үнэтэй түргэн элэгдэх материал, оньсон тоглоом зэрэг бараа материалууд байна.

Мөн бараа материалын дансны үлдэгдлийн өсөлт 2019 онд “Монос Улаанбаатар” ХХК-иас 6,074.9 мянган төгрөгийн анхан шатны тусламжийн барааг хандиваар нийлүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 35,000.0 мянган төгрөгийн акталсан хөрөнгөнөөс хамаарч буурсан байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулсан болон урьдчилж орсон орлого 46,720.7 мянган төгрөгөөр буурснаас өр төлбөр дансны үлдэгдэл буурсан байна.

Өр төлбөрийн дансны 562,105.3 мянган төгрөгийн үлдэгдэл нь хувь хүний орлогын албан татварт төлөх 39,825.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний төлбөрийн өр төлбөр 392,652.9 мянган төгрөг, урьдчилж орсон орлогын 105,645.7 мянган төгрөг, бусад өглөгийн 23,971.7 мянган төгрөгөөс бүрдэж байна. Тухайн байгууллага тайлант оны эцэс дэх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13,449.8 мянган төгрөг болон авлагаа цуглуулах замаар зохицуулж өр төлбөрөө барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант хугацааны нийт үр дүн болох 449,485.3 мянган төгрөгийн алдагдлаас шалтгаалан буурчээ.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хүүхдийн хөгжил хамгааллын 1 хөтөлбөрт зориулан 4,893,447.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4,803,447.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 90,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардалд зарцуулахаар тус тус төлөвлөсөн байна.

Нийт зардлын 4,893,447.3 мянган төгрөгийн 10.2 хувь буюу 497,038.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,396,409.1 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 4,381,214.4 мянган төгрөг бүрдүүлж, төлөвлөгөө 15,194.8 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар насанд хүрэгчдийг хүлээн авахаа зогсоосноос шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,865,154.7 мянган төгрөг буюу 99.42 хувьтай байгаа нь орлого тасарсан болон зардлын хэмнэлттэй холбоотой байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитаар нийт 42,434.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 8,142.0 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 30,262.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4,030.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

1. ОУХНЦогцолборын захирлын А/53 дугаар "ОУХНЦогцолборын 41 жилийн ойн өдрийг зохион байгуулах тухай" тушаалаар 5818.6 мянган төгрөгийг хоол болон бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардлаас тус тус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн



41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 1.1-д “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд зааснаас бусад түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө”, 1.4-д “Байгууллагын тэгш ойг байгуулагдсан өдрөөс хойш 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тухайн салбарын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын удирдлага холбогдох шийдвэр гаргаж тэмдэглэнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. ОУХНЦогцолборын захирлын 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар Цогцолборын нутаг дэвсгэр дэх овооны тахилгын үйл ажиллагаанд 1,532.9 мянган төгрөгийг хоол болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тушаалын хавсралтын 210502-д “хоол, хүнс нь хууль тогтоомжийн дагуу төрөөс хүнсний бүтээгдэхүүн болон хоолоор хангах үйлчилгээтэй холбогдсон зардлыг энэ ангилалд бүртгэнэ”, 214308-д “нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал нь хууль тогтоомжид заасны дагуу албан хаагчид нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж, шагнал, урамшуулал олгохтой холбоотой зардлыг энэ ангилалд бүртгэнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. ОУХНЦогцолборын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/120 дугаар тушаалаар “Цогцолборын 2018 оны үйл ажиллагаанд 10 болон түүнээс дээш сар идэвхи үр бүтээлтэй ажилласан ажилтнуудад нэг хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх урамшууллыг ажилласан сар, ажлын үр дүнг үндэслэн олгох” гэж шийдвэрлэсний дагуу ажилтнуудад урамшуулал өгсөн байна. Уг тушаалын хавсралт дахь урамшуулах ажилтнуудын жагсаалтанд тус цогцолборын захирлын нэр орсон ба холбогдох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр 790.5 мянган төгрөгийн урамшуулал авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4. 2017 онд үүссэн Самбо бөхийн холбооноос авах 23,472.0 мянган төгрөгийн авлага, Мэтгэлцээний үндэсний танхимаас авах 6,790.0 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.6.1-д “Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 4,030.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Олон улсын найрамдал цогцолборын ажилчдын байрны 1-5 өрөө бүхий нийт 12 орон сууцанд тус цогцолбороос тэтгэвэрт гарсан 4 хүн болон хамааралгүй 8 айл өрх амьдарч байгаа нь дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц чухал асуудал юм.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 104 мэдээллийг хугацаанд нь, шилэн дансны цахим систем засвартай байснаас шалтгаалж 42 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,581.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг 10 хувь барагдуулсан, зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс 1 албан шаардлагыг хэрэгжүүлж 1 албан шаардлагын биелэлт 33.3 хувьтай байна.

Нийт 7 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 42,434.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийн дүн бидний тогтоосон 49,852.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т байгууллагаа сурталчилж оролцоход зарцуулсан 1,106.6 мянган төгрөгийн зардлын баримтын бүрдэл хангалтгүй, тухайн ААН-д биш хувь иргэнд олгогдсон сугалааны дугаартай и-баримт байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

#### 1.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлд тусгагдах

#### 1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлэх

#### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллана.

### 2. Хөрөнгийн дэлгэрэнгүй тайлантай холбоотой асуудал

#### 2.1. Илрүүлэлт:

ОУХНЦогцолборын 2019 оны Үндсэн хөрөнгийн болон аж ахуйн материалын хэвлэмэл тайланд эд хариуцагч болон шалгаж хүлээн авсан нягтлан бодогч гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т Ерөнхий нягтлан бодогч нь "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн

байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" үүрэгтэй гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид дэлгэрэнгүй тайлан хөтлөлтийг шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж гарын үсэг зурж баталгаажуулж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид нягтлан бодох бүртгэл хөтлөлт шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж гарын үсэг зурж баталгаажуулж ажиллана.

3. Цалин хөлстэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

ОУХНЦогцолборын захирлын Б/43 дугаар тушаалаар "ОУХНЦогцолборын хөтөлбөр үйл ажиллагаа хариуцсан дэд захиралд докторантурт суралцах болон эмчилгээ хийлгэх өргөдлийг нь харгалзан Цогцолборын хөдөлмөрийн дотоод журмын 9.4.1.3 -д "Ажлын 5 өдөр, түүнээс дээш хугацааны чөлөөг Ерөнхий захирал тушаалаар олгоно" гэж заасныг үндэслэн 3 сарын 2,924.2 мянган төгрөгийн цалинтай чөлөө олгох шийдвэр гаргасан нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үрэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**1.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>802,514,314.86</u></b>	<b><u>929,637,252.96</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	351,928.79	13,449,827.23
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	351,928.79	13,449,827.23
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	351,928.79	13,449,827.23
31211	Төрийн сангийн харилцах	351,928.79	13,449,827.23
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	88,783,870.35	162,736,611.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,874,623.00	10,874,623.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	52,187,600.00	101,777,990.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	25,721,647.35	50,083,998.00
3351	Байгууллагаас авах авлага	25,721,647.35	50,083,998.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	39,250,000.00	27,700,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	39,000,000.00	27,000,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	250,000.00	700,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	250,000.00	700,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	674,128,515.72	725,750,814.73
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	446,342.63	218,383.00
35130	Эм боох материал	446,342.63	218,383.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	673,682,173.09	725,532,431.73
35420	Аж ахуйн материал	175,074,110.62	193,369,129.60
35430	Сэлбэг хэрэгсэл	957,000.00	3,204,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,808,350.00	5,210,300.00
35460	Хүнсний материал	30,748,531.64	27,918,933.80
35470	Бусад хангамжийн материал	465,094,180.83	495,829,568.33
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15,158,334,805.60</u></b>	<b><u>14,496,342,323.62</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	15,158,334,805.60	14,496,342,323.62
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	15,008,111,605.81	14,356,439,670.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,539,043,729.00	13,566,452,979.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,484,537.62	-510,353,374.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	407,183,476.70	401,983,476.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	(328,996,252.55)	(34,615,119.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,786,045,481.66	1,827,313,171.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,071,461,219.09)	(1,200,973,504.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	723,986,359.56	736,376,359.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(492,612,466.14)	(530,564,877.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	514,765,693.53	518,265,693.53
39215	Хуримтлагдсан элэгдэл	(63,358,659.24)	(117,445,134.16)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	150,223,199.79	139,902,652.99
39301	Програм хангамж	8,692,044.00	8,692,044.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,552,044.00)	(8,692,044.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	152,708,200.00	152,708,200.00

39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,625,000.21)	(12,805,547.01)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>15,960,849,120.46</u></b>	<b><u>15,425,979,576.58</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>647,489,620.94</u></b>	<b><u>562,105,363.49</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	647,489,620.94	562,105,363.49
<b>413</b>	<b>Өглөг</b>	495,123,268.94	456,459,663.49
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	199,703,968.29	39,835,928.44
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	269,186,600.65	392,652,072.05
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	26,232,700.00	23,971,663.00
41361	Байгууллагад төлөх өглөг	26,232,700.00	22,806,730.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,164,933.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	152,366,352.00	105,645,700.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	152,366,352.00	105,645,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>15,313,359,499.52</u></b>	<b><u>14,863,874,213.09</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	15,313,359,499.52	14,863,874,213.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,201,162,456.84	6,201,162,456.84
51101	Өмч: - төрийн	6,201,162,456.84	6,201,162,456.84
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(2,495,051,723.38)	(2,944,537,009.81)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,495,051,723.38)	(2,495,051,723.38)
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(449,485,286.43)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,607,248,766.06	11,607,248,766.06
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>15,960,849,120.46</u></b>	<b><u>15,425,979,576.58</u></b>

#### 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,788,729,021.94</b>	<b>4,985,287,679.44</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,099,860,876.94</b>	<b>4,488,249,479.44</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,066,471,003.94	4,482,174,579.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,009,722,910.67	4,467,202,135.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,593,362,865.50	4,271,350,043.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	416,360,045.17	195,852,092.18
120005	Түрээсийн орлого	3,568,000.00	6,873,000.00
120009	Бусад орлого	53,180,093.27	8,099,444.26
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	33,389,873.00	6,074,900.00
122001	Хандив тусламж /дотоод/	33,389,873.00	6,074,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>688,868,145.00</b>	<b>497,038,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	497,038,200.00	497,038,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	497,038,200.00	497,038,200.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	191,829,945.00	00.00
133003	Хөрөнгийн	191,829,945.00	00.00



<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,973,210,806.70</b>	<b>5,434,772,965.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,973,210,806.70</b>	<b>5,434,772,965.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,930,953,822.40	5,362,091,625.87
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,324,556,852.52	1,498,507,805.59
210101	Үндсэн цалин	1,190,301,221.52	1,369,532,643.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,623,000.00	74,801,320.00
210105	Гэрээт ажлын хөлс	79,632,631.00	54,173,842.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	158,827,257.64	192,255,917.89
210201	Тэтгэврийн даатгал	109,290,577.64	139,980,982.89
210202	Тэтгэмжийн даатгал	12,916,614.00	13,462,103.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,162,411.00	10,580,242.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,376,605.00	2,536,954.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,081,050.00	25,695,636.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	706,627,981.88	833,228,316.83
210301	Гэрэл, цахилгаан	262,275,364.70	308,771,790.15
210302	Түлш, халаалт	219,024,329.41	285,128,806.40
210303	Цэвэр, бохир ус	225,328,287.77	239,327,720.28
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	410,903,782.52	407,957,224.98
210401	Бичиг хэрэг	15,905,129.75	7,367,052.50
210402	Тээвэр, шатахуун	184,013,470.00	200,173,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,276,955.23	12,129,611.94
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,849,278.00	41,496,211.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,237,470.51	130,057,197.43
210408	Бараа материал акталсны зардал	71,521,479.03	16,733,802.11
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,312,250,127.86	1,381,920,041.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,468,137.37	2,789,945.63
210502	Хоол, хүнс	1,251,628,407.49	1,324,039,136.84
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	58,153,583.00	55,090,959.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	212,891,459.60	120,499,437.87
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,211,716.00	3,747,000.00
210602	Тавилга	38,753,800.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,067,686.00	00.00
210604	Урсгал засвар	148,858,257.60	116,752,437.87
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	24,812,217.80	12,325,900.00
210701	Гадаад албан томилолт	24,812,217.80	12,325,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	93,248,751.10	76,620,094.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,166,900.00	62,782,564.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,482,880.00	4,030,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,834,930.00	5,261,236.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,139,500.00	919,830.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,118,724.00	311,000.00
